



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/13/СТА-ТТЗ

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум. Аймгийн
ЗДТГ-ын байр “А” корпус, 3
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: www.audit.mn

2021 он

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Цахим хаяг: ulambayard@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Алтантуяа

Утас: 99338611

Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	9
3.5.1 Мөнгөн хөрөнгө	9
3.5.2 Авлага.....	9
3.5.3 Бараа материал	10
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.5 Өр төлбөр.....	12
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	12
3.5.7 Орлогын данс	12
3.5.8 Зардлын данс	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
3.7 Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	17
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	18
3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	20
4. Менежментийн захидал.....	20
4.1. Орлогын данстай холбоотой асуудал.....	20
4.2 Балансын данстай холбоотой асуудал	21
4.3 Балансын данстай холбоотой асуудал	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

1. Аудитын гэрчилгээ


**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХОТОНТ СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Д.БАТБААТАР ТАНАА

2021.03.31 № 138
танай _____ -ны № _____ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилт 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.УЛАМБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	585,942.8	608,550.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	123,442.3	46,625.6
33	АВЛАГА	314,523.9	379,183.7
35	БАРАА МАТЕРИАЛ	147,976.6	182,740.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,139,084.7	5,291,245.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,139,084.7	5,291,245.7
39200	Биет хөрөнгө	4,992,336.7	5,144,497.7
39300	Биет бус хөрөнгө	146,748.0	146,748.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,725,027.5	5,899,795.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,725,027.5	5,899,795.9
51	Засгийн газрын хувь оролцоо	5,725,027.5	5,899,795.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,113,349.7	3,113,349.7
51200	Хуримтлагдсан үр дүн	859,957.8	1,034,726.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,751,720.0	1,751,720.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,725,027.5	5,899,795.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,346,685.2	3,638,193.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	164,327.0	177,625.8
110	Орлогын албан татвар	104,171.1	112,548.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	104,171.1	112,548.7
113	Хөрөнгийн албан татвар	2,190.0	3,600.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	57,965.9	61,477.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,447.8	399,433.8
120	Нийтлэг татварын бус орлого	124,447.8	399,433.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,057,910.4	3,061,133.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,479,788.8	3,385,355.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,479,788.8	3,385,355.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,944,776.2	3,248,913.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,806,355.8	2,166,097.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,560.2	289,217.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,434.3	119,845.4
2104	Хангамж, бараа материалын зардал	105,520.6	111,481.6
2105	Нормативт зардал	206,561.9	188,156.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,072.0	22,221.0
2107	Томилолт, зочны зардал	12,776.0	5,998.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,111.5	60,060.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	418,384.0	285,835.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	535,012.5	136,441.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-133,103.5	252,838.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	108,175.4	78,070.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-241,278.9	174,768.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,309,541.2	3,319,644.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	164,327.0	177,625.8
110	Орлогын албан татвар	104,171.1	112,548.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	104,171.1	112,548.7
113	Хөрөнгийн албан татвар	2,190.0	3,600.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	57,965.9	61,477.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,631.1	6,274.4
1181	Газрын төлбөр	27,047.0	40,148.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	19,287.8	15,053.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,303.8	80,884.3
120	Нийтлэг татварын бус орлого	87,303.8	80,884.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,057,910.4	3,061,133.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,132,423.3	3,143,240.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,132,423.3	3,143,240.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,597,165.2	3,006,362.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,807,365.0	2,161,335.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,014.1	293,979.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,234.1	122,074.8
2104	Хангамж, бараа материалын зардал	78,385.2	107,515.1
2105	Нормативт зардал	212,852.1	152,331.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,027.5	24,510.0
2107	Томилолт, зочны зардал	12,976.0	5,998.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,535.4	63,457.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,775.8	75,161.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	535,258.1	136,878.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	177,117.9	176,403.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	189,288.4	114,220.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	189,288.4	114,220.0
2200	Дотоод эх үүсвэрээр	189,288.4	114,220.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-189,288.4	-114,220.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-139,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	139,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-12,170.5	-76,816.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	135,612.8	123,442.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	123,442.3	46,625.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,966,306.3	5,966,306.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,966,306.3	5,966,306.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-241,278.9	-241,278.9
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,725,027.5	5,725,027.5
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,725,027.5	5,725,027.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,725,027.5	5,725,027.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	174,768.4	174,768.4
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,899,795.9	5,899,795.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,389,042.1	3,300,841.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,129,241.6	3,057,771.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,033,956.9	2,974,266.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,167,065.8	2,161,335.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	293,979.3	293,979.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,850.8	120,850.8
2104	Хангамж, бараа материалын зардал	94,369.4	90,190.1
2105	Нормативт зардал	199,262.8	152,331.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,810.0	29,810.0
2107	Томилолт, зочны зардал	5,998.3	5,998.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,194.5	54,345.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,426.0	65,426.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,284.7	83,504.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,050.5	104,070.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	147,750.0	139,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	147,750.0	139,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,389,042.1	3,240,853.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,368,260.7	2,306,801.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	766,520.3	820,670.6

33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,137.8	38,426.8
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,137.8	38,426.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	209,123.3	74,954.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	69,177.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,189.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8
610001	Төсвийн байгууллага	8	8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	189.5	189.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,245.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,245.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,245.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,224.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,325.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,111.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,585.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,245.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,245.8
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,959.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,238.6

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хотонт сумын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Д.Батбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсөв захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Н.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хотонт сум нь тайлант жилд ил тод байдлыг хангасан оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжлийг тодорхойлж, төрийн үйлчилгээг түмэн олондоо шуурхай тасралтгүй хүргэх зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар тогтоол
- “Автомашинны жишиг норм батлах тухай” Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хотонт сум нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

2020 онд ТЕЗ-ийн харьяа аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийсэн байна. Харин Сумын төсөвт байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Хотонт сумын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөөгүй байна гэж үнэллээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал / устгах бичилт хийгдсэн/ 3,463,425.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 34,634.2 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл **123,442.3** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **46,625.6** мянган төгрөг болж, **76,816.7** мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа мөнгө-Төрийн сан	123,442.3	46,625.6	(76,816.7)
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Орон нутгийн ерөнхий орлого	54,264.8	37,435.9	(16,828.9)
ОНХС	1,858.5	7,980.5	6,122.0
Сум хөгжүүлэх сан	67,319.0	1,209.2	(66,109.8)
Дүн	123,442.3	46,625.6	(76,816.7)

Эх сурвалж: Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 46,625.6 мянган төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд 76,816.7 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн ерөнхий орлого болон сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл өмнөх оноос буурсантай холбоотой байна.

Нийт мөнгөн хөрөнгийн 80.3 хувь буюу 37,435.9 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны, 17.1 хувь буюу 7,980.5 мянган төгрөг нь ОНХСангийн, 2.6 хувь буюу 1,209.2 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл **314,523.9** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **379,183.7** мянган төгрөг болж, **64,659.8** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүнээс авах авлага	314,523.9	379,183.7	64,659.8
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	314,523.9	379,183.7	64,659.8

Эх сурвалж: Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл **64,659.8** мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд СХС-ийн зээл олголт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт авлагын үлдэгдэл нь СХС-аас олгосон хувь хүнээс авах авлага байна.

СХСангийн зээлийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 262,196.3 мянган төгрөг буюу 69.1 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 116,987.4 мянган төгрөг буюу 30.9 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийг төлүүлэхээр засаг даргын хугацаатай мэдэгдэл хүргүүлэн, шүүхэд шилжүүлэн ажилласан байна.

Илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангаас олгосон 116,987.4 мянган төгрөгийн 18 зээлдэгчтэй холбоотой хугацаа чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл **147,976.6** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **182,740.8** мянган төгрөг болж, **34,764.2** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	15,638.7	19,284.2	3,645.5
Бэлэн бүтээгдэхүүн	520.0	964.0	444.0
Хангамжийн материал	131,817.9	162,492.6	30,674.7
Дүн	147,976.6	182,740.8	34,764.2
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
ЗДТГ	32,498.8	37,565.0	5,066.2
ЕБС	76,271.6	101,495.3	25,223.7
Хүүхдийн цэцэрлэг	2,797.8	1,833.6	(964.2)
Өндөр сант цэцэрлэг	1,249.4	770.9	(478.5)
Бага сургууль	8,682.4	9,253.1	570.7
Соёлын төв	11,769.8	14,262.2	2,492.4
Эрүүл мэндийн төв	14,706.8	17,560.7	2,853.9
	147,976.6	182,740.8	34,764.2

Эх сурвалж: Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл **34,764.2** мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал дансанд тайлагнагдсан аж ахуйн материал өссөнтэй холбоотой байна.

Нийт бараа материал үлдэгдлийн 55.6 хувь буюу 101,495.3 мянган төгрөг нь ЕБС-ийн, 20.6 хувь буюу 37,565.0 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 5.0 хувь буюу 9,253.1 мянган төгрөг нь бага сургуулийн, 7.8 хувь буюу 14,262.2 мянган төгрөг нь

соёлын төвийн, 9.6 хувь буюу 17,560.7 мянган төгрөг нь эрүүл мэндийн төвийн, 1.0 хувь буюу 1,833.6 мянган төгрөг хүүхдийн цэцэрлэгийн, 0.4 хувь буюу 770.9 мянган төгрөг нь нь Өндөрсант багийн цэцэрлэгийн бараа материалын үлдэгдэл тус тус байна.

Бараа материалын данс нь оны эхэнд 147,976.6 мянган төгрөг ба тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 393,186.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 42,170.9 мянган төгрөг, бусдаар хүлээж авсан 18,545.9 мянган төгрөг нийт 453,903.1 мянган төгрөгөөр нэмэгдэн, зарцуулсан 419,138.9 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 182,740.8 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт бараа материалын 88.9 хувийг хангамжийн материал, 10.6 хувийг түүхий эд материал, 0.5 хувийг бэлэн бүтээгдэхүүн эзэлжээ.

Илрүүлэлт:

- ИТХ- 11,734.2 мянган бараа материал худалдан авч зарцуулсаныг анхан шатны баримтаас хөөн шалгахад няравын тайлан тооцоо гаргаагүй, санхүүгийн программд түлш шатахууныг бөөн дүнгээр орлогод авч, бөөн дүнгээр зарлагадсан зөрчил илэрч зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл **5,139,084.7** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **5,291,245.7** мянган төгрөг болж, **152,161.0** мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,992,336.7	5,144,497.7	152,161.0
Биет бус хөрөнгө	146,748.0	146,748.0	-
Дүн	5,139,084.7	5,291,245.7	152,161.0
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
ИТХ	4,000.2	4,578.3	578.1
ЗДТГ	2,104,402.7	2,376,919.5	272,516.8
ЕБС	1,896,146.1	1,811,248.2	(84,897.9)
Хүүхдийн цэцэрлэг	387,407.1	389,595.2	2,188.1
Өндөр сант цэцэрлэг	2,356.5	1,957.5	(399.0)
Бага сургууль	228,931.7	215,204.1	(13,727.6)
Соёлын төв	155,202.9	148,113.6	(7,089.3)
Эрүүл мэндийн төв	360,637.5	343,629.3	(17,008.2)
	5,139,084.7	5,291,245.7	152,161.0

Эх сурвалж: Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 44.9 хувь буюу 2,376,919.5 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 34.2 хувь буюу 1,811,248.2 мянган төгрөг нь ЕБС-ийн, 7.4 хувь буюу 389,595.2 мянган төгрөг хүүхдийн цэцэрлэгийн, 6.5 хувь буюу 343,629.3 мянган төгрөг нь эрүүл мэндийн төвийн 4.1 хувь буюу 215,204.1 мянган төгрөг нь бага сургуулийн, 2.8 хувь буюу 148,113.6 мянган төгрөг нь соёлын төвийн, 0.1 хувь буюу 4,578.3 мянган төгрөг нь сумын ИТХ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл тус тус байна.

Үндсэн хөрөнгө данс нь тайлант оны эхэнд 5,139,084.7 мянган төгрөг ба төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 36,150.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 15,593.9 мянган төгрөг, бусдаар 314,579.0 мянган төгрөг нийт 368,322.9

мянган төгрөгөөр нэмэгдэн, тайлант хугацаанд байгуулсан элэгдэл 216,161.9 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 5,291,245.7 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн 97.3 хувийг биет хөрөнгө, 2.7 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Илрүүлэлт:

- ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 25 нэр төрлийн 33,417.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 16 нэр төрлийн 4,884.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 38,301.9 мянган үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаад холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.
- ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд сумын ЕБС, хүүхдийн цэцэрлэгт ашиглагдаж байгаа тус бүр нь 1,200.0 мянган төгрөгийн өртөгтэй нийт 2,400.0 мянган төгрөгийн СИ ТИ ЭС санхүүгийн программ бүртгэлтэй байсанд ашиглагч байгууллагад шилжүүлэн өгөх зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.
- ЕБС- Элэгдлээ бүрэн нөхсөн 87ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

3.5.5 Өр төлбөр

Богино болон урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **5,725,027.5** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **5,899,795.9** мянган төгрөг болж, **174,768.4** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,113,349.7	3,113,349.7	-
Хуримтлагдсан үр дүн	859,957.8	1,034,726.2	174,768.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,751,720.0	1,751,720.0	-
Дүн	5,725,027.5	5,899,795.9	174,768.4

Эх сурвалж: Хотонт сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл **174,768.4** мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,638,193.5 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 177,625.8 мянган төгрөг,

2. Татварын бус орлого 399,433.8 мянган төгрөг тайлагнагдсаны 5,429.6 мянган төгрөг нь торгуулийн орлого, 393,504.2 мянган төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлого, 500.0 мянган төгрөг нь бусад орлого байна. Үүнээс төсөвт байгууллагын өөрийн орлогыг задалж авч үзвэл үндсэн үйл ажиллагааны орлого 614.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 392,889.7 мянган төгрөг тус тус байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 3,061,133.9 мянган төгрөгөөр тайлагнасныг нэр төрлөөр нь задалж авч үзвэл: тусгай зориулалтын шилжүүлгээс 2,360,175.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 42,245.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 620,286.3 мянган төгрөг, ЭМДСангаас 38,426.8 мянган төгрөг тус тус байна.

3.5.8 Зардлын данс

Сумын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардал 3,385,355.1 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 78,070.0 мянган төгрөг, нийт 3,463,425.1 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна. Өмнөх оноос бараа үйлчилгээний урсгал зардал 304,137.3 мянган төгрөгөөр өссөн нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Илрүүлэлт:

- ЗДТГ- 1,316.5 мянган төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулсан,
- ИТХ- 225.0 мянган төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулсан,
- Хүүхдийн цэцэрлэг- Хоол хүнс, түлш халаалтын зардлаас 2,526.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- ЭМТ- Төсөвт зохицуулалт хийхгүйгээр 3,164.6 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан,
- Өндөрсантын цэцэрлэг- Төсөвт зохицуулалт хийхгүйгээр урсгал засварын батлагдсан зардлаас 460.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн зэрэг дээрх зөрчлүүдэд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.
- ЗДТГ -Анхан шатны баримтгүйгээр 1,670.0 мянган төгрөгийг зарцуулан, 195.0 мянган төгрөгийг засаг даргын захирамжийн мөнгөн дүнгээс илүү тооцож шилжүүлсэн,
- ЭМТ- Бараа үйлчилгээний бусад зардлаас анхан шатны баримтгүй 1250,0 мянган төгрөгийн зарцуулан 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан,
- ЭМТ- 682.1 мянган төгрөгийн цалин, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон,
- Өндөрсант бага сургууль- 356.8 мянган төгрөгийн цалин, үр дүнгийн урамшуулал илүү олгосон зэрэг зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон.
- Өндөрсант бага сургууль- Цалингийн давтан тооцооллоор 11 сар 3,328.4 мянган төгрөгийн, 12 сард 3403.4 мянган төгрөгийн нийт 6,731.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг нийт ажилчдад хавтгайруулан олгосон,
- Өндөрсантын цэцэрлэг- 2020 оны 11, 12 саруудад бүх ажилтнуудад ижил хувь хэмжээгээр ур чадварын нэмэгдэл тооцож олгосон
- ЕБС- Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн,
- Сумын төсөвт байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй зэрэг зөрчлүүдэд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Дээрх зөрчүүдээс харахад сумын санхүүгийн албанаас төсөвт байгууллагуудын төлбөр тооцоонд тавих сул байгааг харуулж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлтийн талаар:

Орон нутгийн төсвийн орлогыг 79,218.5 мянган төгрөгөөр анх төлөвлөж, дээд шатны байгууллагад хүргүүлснийг 8,003.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 87,222.0 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд аймгаас хөрөнгийн орлогыг 17,007.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогыг 4,000.0 мянган төгрөг, бууны албан татварыг 240.0 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 510.0 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрийг 2,502.9 мянган төгрөг, ус рашаан ашигласны төлбөрийг 450.0 мянган төгрөг, хүү торгуулийн орлогыг 2,000.0 мянган төгрөг, нэр заагдаагүй бусад орлогыг 300.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, харин шууд бус орлогыг 14,200.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлогыг 4,872.0 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг 150.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Харин төсвийн тодотголоор нийт орлогыг 59,512.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан ба шууд бус орлогыг 26,000.0 мянган төгрөгөөр газрын дуудлага худалдааны орлогыг 38,121.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 234.0 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийг 4,309.1 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгосон байна.

Хотонт сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг **3,570,110.5** мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор **3,391,542.1** мянган төгрөг болж, **178,568.4** мянган төгрөгөөр бууруулсан байна.

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан бол Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс 224,383.9 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгол хийгдсэн байна.

Хүснэгт 7. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн орлого	86,722.0	146,234.1	59,512.1
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	153,000.0	153,000.0	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	319,699.6	290,392.7	(29,306.9)
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	85,692.1	84,192.0	(1,500.1)
5	СӨБ-ийн үйлчилгээ	460,271.5	421,565.6	(38,705.9)
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,813,733.5	1,628,055.5	(185,678.0)
7	Соёлын үйлчилгээ	134,240.8	134,240.8	-
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	478,892.5	477,738.2	(1,154.3)
9	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	36,000.0	54,264.8	18,264.8
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	1,858.5	1,858.5	-
	Нийт дүн	3,570,110.5	3,391,542.1	(178,568.4)

1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	79,219.6	81,219.6	2,000.0
2	Засаг даргын тамгын газар	363,702.0	410,171.9	46,469.9
3	Орон нутгийн хөгжлийн сан	87,550.6	86,050.5	(1,500.1)
4	Сум хөгжүүлэх сан	150,000.0	150,000.0	-
5	Сургуулийн өмнөх боловсрол	460,271.5	421,565.6	(38,705.9)
6	Ерөнхий боловсролын сургууль	1,813,733.5	1,628,055.5	(185,678.0)
7	Соёлын төв	136,740.8	136,740.8	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	478,892.5	477,738.2	(1,154.3)
	Нийт дүн	3,570,110.5	3,391,542.1	(178,568.4)

✓ **Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:**

Хотонт сумын ИТХ-ын 2020 оны сумын 2020 оны төсөв тодотгон батлах тухай 04-р тогтоолд сумын төсвийн орлогоор 17 нэр төрлийн 146,734.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 184,169.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 125.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Сумын орон нутгийн төсвийн орлого /мянган төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	146,734.1	184,169.9	37,435.8	125.5
2.УРСГАЛ ОРЛОГО	146,734.1	184,169.9	37,435.8	125.5
3.ТАТВАРЫН ОРЛОГО	135,584.1	177,625.8	42,041.7	131.0
4.Орлогын албан татвар	74,950.0	112,548.6	37,598.6	150.2
Хүн амын орлогын албан татвар	74,950.0	112,548.6	37,598.6	150.2
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар			0.0	
Үйл ажиллагааны орлого	5,000.0	3,303.1	-1,696.9	66.1
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	39,000.0	44,381.8	5,381.8	113.8
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	150.0	1,570.2	1,420.2	1,046.8
Шууд бус орлого	30,800.0	63,293.5	32,493.5	205.5
Өмчийн татвар	3,270.0	3,600.0	330.0	110.1
Үл хөдлөх хөрөнгийн татвар			0.0	
Бууны албан татвар	3,270.0	3,600.0	330.0	110.1
Бусад татвар	57,364.1	61,477.2	4,113.1	107.2
Улсын тэмдэгтийн хураамж	1,960.0	3,286.3	1,326.3	167.7
Газрын төлбөр	38,379.2	40,148.8	1,769.6	104.6
-----газрын төлбөр		1,829.4	1,829.4	
-----Газрын дуудлага худалдааны орлого	38,379.2	38,319.4	-59.8	99.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	776.0	901.2	125.2	116.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	2,087.0	87.0	104.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	14,248.9	15,053.9	805.0	105.6
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	20.0	20.0	0.0	100.0
----- ус рашааны нөөц ашигласны төлбөр	1,750.0	2,000.0	250.0	114.3
-----ойн нөөц ашигласны төлбөр	12,412.9	12,967.9	555.0	104.5
----- ан амьтаны нөөц ашигласны төлбөр	66.0	66.0	0.0	100.0
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,150.0	6,544.1	-4,605.9	58.7
Төсөвт газрын өөрийн орлого	500.0	614.5	114.5	122.9
Хүү торгуулийн орлого	10,150.0	5,429.6	-4,720.4	53.5
Нэр заагдаагүй бусад орлого	500.0	500.0	0.0	100.0

Тайлант жилд 14 нэр төрлийн орлого давж биелэсэн бол үйл ажиллагааны орлого 1,696.9 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 59.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 4,720.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь коронавирус /Ковид-19/ цар тахал гарсантай холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоож, зорчих хөдөлгөөн багассан, худалдаа үйлчилгээ явуулдаг хувь иргэдийн төлдөг татвар буурсан зэрэгтэй холбоотой байна.

✓ **Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:**

Хотонт сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор **3,570,110.5** мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 04 тоот тогтоолоор төсөвт тодотгол хийж, ИТХ-д 2,000.0 мянган төгрөг, ЗДТГ-т 46,469.9 мянган төгрөгийн нэмэх, ОНХС-д 1,500.1 мянган төгрөг, ЭМТ-д 1,153.4 мянган төгрөгийн, СӨБ-т 37,705.9 мянган төгрөг, ЕБС-д 185,678.0 мянган төгрөгийн хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг **3,391,542.1** мянган төгрөгөөр баталжээ.

ЕБС-ийн үдийн цай, хоолны зардлаас 2,500.0 мянган төгрөгийг 2020 оны 12-р сард Сангийн яам татсанаас шалтгаалан нийт зарлагын төлөвлөгөө **3,389,042.1** мянган төгрөг болж буурсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,389,042.1 мянган төгрөг төлөвлөснөөс 3,129,241.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 112,050.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 147,750.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар төлөвлөж, нийт зардлын 2,368,260.7 мянган төгрөг буюу 69.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 766,520.3 мянган төгрөг буюу 22.6 хувийг орон нутгийн төсвөөс, 209,123.3 мянган төгрөг буюу 6.2 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 45,137.8 мянган төгрөг буюу 1.3 хувийг ЭМДС-аас санхүүжүүлэхээр хуваарилсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,300,841.4 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь урсгал зардлаас 71,470.2 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 7,980.5 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 8,750.0 мянган төгрөг тус тус хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХС-ийн хөрөнгөөр 4 төсөл, арга хэмжээнд 86,050.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 78,070.0 мянган төгрөгийг 3 төсөл арга хэмжээнд зарцуулж, 1 төсөл арга хэмжээ санхүүжилт дутуу орж ирсэнээс шалтгаалан бүрэн дуусаагүй 2021 онд хүлээж авахаар хойшилсон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 37,959.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,238.6 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив тусламж 47.4 мянган төгрөг нийт 42,245.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,224.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 17,325.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 9,111.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 14,585.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 58 мэдээллээс хугацаандаа оруулсан 47 , хугацаа болоогүй 2 , хугацаа хоцроосон 9 мэдээллийг тус тус шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Илрүүлэлт:

- ЗДТГ- 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас бүтэн жилээр, аудитын тайлан, дүгнэлт зэргийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.
- ИТХ- Шилэн дансны цахим хуудсанд дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг байршуулаагүй, 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.
- Соёлын төв- 1 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 44,624.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн дээрх зөрчлүүдэд зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 202,300.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж-ОНО	1	3,521.1	1	3,521.1			100
Зөвлөмж-СХСан	1	198,778.9	1	81,791.5	1	116,987.4	40
Нийт	2	202,300.0	2	85,312.6	1	116,987.4	70

СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар албан бичгээр зөвлөмжийн хариуг ирүүлсэн бөгөөд энэ жил хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 81,791.5 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байгаа тул биелэлтийг 40 хувьтай байна гэж үзэн тайлант оны аудитаар дахин зөвлөмж хүрүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн өмнөх онд 2 нэр төрлийн орлого тасарсанд зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулсан бөгөөд энэ онд өмнөх онд тасарсан 2 нэр төрлийн орлогоос өөр 3 нэр төрлийн орлого тасарсан тул дахин зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Хотонт сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 8 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Хотонт сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №10.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	үнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1		1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1	1		1	1			
Өндөрсант багийн цэцэрлэг	1	1		1					
Өндөрсант багийн бага сургууль	1	1		1					
ЗДТГ	1	1	1		1	1			
ИТХурал	1	1	1		1		1		
Соёлын төв	1	1		1					
ЭМТөв	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
НИЙТ ДҮН	10	10	5	5	5	4	1	0	0

Сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан сумын ЗДТГ, ЕБС, хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, харин ИТХ-д “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 115,638.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, 4,153.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64,050.8 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн, 47,433.7 мянган төгрөгийн 12 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил бүгд залруулагдаагүй алдаа зөрчил байна.

Хүснэгт №11. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЕБСургууль	3	-					3	-
Хүүхдийн цэцэрлэг	3	2,526.2			1	2,526.2	2	-
Өндөрсант багийн цэцэрлэг	2	460.0			1	460.0	1	-
Өндөрсант багийн бага сургууль	2	7,088.6	1	356.8			1	6,731.8
ЗДТГ	6	43,883.4	1	1,865.0	2	1,316.5	3	40,701.9
ИТХурал	3	11,959.2			2	11,959.2	1	-
Соёлын төв	1	44,624.3			1	44,624.3		
ЭМТөв	4	5,096.7	2	1,932.1	1	3,164.6	1	-
НИЙТ ДҮН	24	115,638.4	4	4,153.9	8	64,050.8	12	47,433.7

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал НББ тайлагналтай холбоотой 52,436.1 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 54,471.1 мянган төгрөгийн, зориулалт бус зарцуулсан 7,692.3 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 1,038.9 мянган төгрөгийн алдаа зөрчил тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Хотонт сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар **262,464.5** мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, аудитын явцад **139,000.0** мянган төгрөгийн алдааг залруулж, **123,464.5** мянган төгрөгийн зөрчилд менежмент захидлаар зөвлөмж хүргүүллээ. Хүснэгт №12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулагдсан алдаа, зөрчлийн дүн		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	1	139,000.0	1	116,987.4					1	116,987.4
ОНОрлого			1	6,477.1					1	6,477.1
Нэгдсэн тайлан			1	-					1	-
НИЙТ ДҮН	1	139,000.0	3	123,464.5	0	0	0	0	3	123,464.5

1. Орон нутгийн орлогод 17 нэр төрлийн 146,734.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 184,169.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 125.5 хувиар давуулан биелүүлсэн боловч үйл ажиллагааны орлого 1,696.9 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 59.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 4,720.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан тул аудитаас орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмжийг сумын удидлагад хүргүүллээ.
2. СХС нь нийт 57 хүнтэй холбоотой 379,183.7 мянган төгрөгийн зээлийн авлагтайгаас 39 хүнтэй холбоотой 262,196.3 мянган төгрөг нь хэвийн зээл, 18 хүнтэй холбоотой 116,987.4 мянган төгрөг нь чанаргүй зээл байгаа тул холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг сумын удидлагад хүргүүллээ.
3. СХС-аас тайлант онд 139,000.0 мянган төгрөгийн зээл олгосон тус зээлийг үр дүнгийн тайланд зардлаар бүртгэж тайлагнасныг аудитын явцад авлагаар бүртгүүлэн залруулга хийлгэлээ.

3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлсэн эсэх, мөн СХС-ийн чанаргүй зээлийг төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан эсэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нягтлан шалгана.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Тайлант жилд 14 нэр төрлийн орлого давж биелэсэн бол үйл ажиллагааны орлого 1,696.9 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 59.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 4,720.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.1.2 Эрсдэл:

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч, төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

4.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.2.1 Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас олгосон 116,987.4 мянган төгрөгийн 18 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.

4.2.2 Эрсдэл:

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

4.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.3.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 115,638.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, 4,153.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64,050.8 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэн, 47,433.7 мянган төгрөгийн 12 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өгч ажилласан байна. Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлүүдийн 16.2 хувийг төсвийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй зэрэг зөрчлүүд эзэлж байгаа нь сумын санхүүгийн албанаас төсөвт байгууллагуудын төлбөр тооцоонд тавих хяналт сул байгаагаас шалтгаалсан байна.

4.3.2 Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн хөрөнгө үр дүнгүй, зориулалт бус зарцуулагдах

4.3.3 Өгсөн зөвлөмж:


Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч, санхүүгийн албаны хяналт, шалгалтыг сайжруулах

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Архангай аймгийн Хотонт сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			АРА-2021/13/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хотонт сумын ТЕЗ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Тоо	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Сум хөгжүүлэх сангаас олгосон 116,987.4 мянган төгрөгийн 18 зээлдэгчтэй холбоотой чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.	1	116,987.4	Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх	Хотонт сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Батбаатар, Н.Сангачамаа
2	Тайлант жилд 14 нэр төрлийн орлого давж биелэсэн бол үйл ажиллагааны орлого 1,696.9 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 59.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 4,720.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан	1	6,477.1	Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх	Хотонт сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Батбаатар, Н.Сангачамаа
3	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлүүдийн 16.2 хувийг төсвийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй зэрэг зөрчлүүд эзэлж байгаа нь сумын санхүүгийн албанаас төсөвт байгууллагуудын төлбөр тооцоонд тавих хяналт сул байгаагаас шалтгаалсан байна.	1	-	Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх	Хотонт сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Батбаатар, Н.Сангачамаа
4	СХС-аас тайлант онд 139,000.0 мянган төгрөгийн зээл олгосон тус зээлийг үр дүнгийн тайланд зардлаар бүртгэж тайлагнасныг аудитын явцад авлагаар бүртгүүлэн залруулга хийлгэлээ.	1	139,000.0	Санхүүгийн тайланд залруулсан	Хотонт сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Д.Батбаатар, Н.Сангачамаа
	Дүн	4	262,464.5			